

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 16/438

ШУС, НУС

2015

**МЭДЭЭЛЛИЙН ДАЙНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ,
ТҮҮНИЙ МӨН ЧАНАР**

Б.Наранбаатар *

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: мэдээллийн дайн, ухуулга сурталчилгаа, мэдээллийн аюулгүй байдал, үндэсний эрх ашиг, мэдээллийн тэнцвэрт байдал, олон улсын сэтгүүл зүй, гадаад бодлого, манипуляци, мэдээллийн цөмрөлт, соёлын түрэлт

Дэлхий даяар мэдээлэл, мэдлэгийн үнэ цэн, ач холбогдлыг “магтан дуулж”, орчин үеийн хөгжлийн хандлага, ирээдүйн бүтээн байгуулалт, улс орны хөгжлийн хэв загвар бүхнийг мэдээлэл, мэдээллийн технологитой холбон үзэх болсон билээ. 1960-д оноос анх шинжлэх ухааны зөгнөл хэлбэрээр бий болсон мэдээллийн нийгмийн үйл явц улам бүр батжин бэхжиж, биеллээ олж байна.

Мэдээллийг бий болгох, боловсруулах, хадгалах, дамжуулан түгээх арга хэрэгслүүд улам бүр даяаршин мөн хямдрахын зэрэгцээ мэдээллийн нөлөөллийн олон хэлбэрийг дахин сөхөж тодорхойлох, шинээр шинжлэх ухааны зарчимтайгаар хандан нэгдмэл ойлголтонд хүрэх, мөн түүний сөрөг үр дагавар, эсвэл эерэг үр нөлөөний асуудлыг цэгцтэй авч үзэх шаардлага урган гарч байна.

Үндэсний болон нийтийн аюулгүй байдлын ойлголтуудын зааг ялгаа замхран бүдгэрч, ОНМХ-ийн гадаад, дотоод мэдээлэл цар хүрээ, ач холбогдол, шуурхай нөлөөллийн хувьд улам бүр ойртох болсон нь зорилтот мэдээллийн харилцааг олон улс, тив дэлхийн түвшинд аваачих болов.

ЗХУ задарснаар хуучин социалист дэглэм, хаалттай хоёр туйлт олон улсын харилцааны систем нуран унаж, энэ салбарын шилдэг шинжээчид дэлхий нийтийн хөгжлийн дараагийн үе шатын талаарх өөдрөг үзэл баримтлал газар авч байсан үе саяхан. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн, дэлхий нийтийг хагаралдуулан, тэмцэл зөрчлийн эх үүр болж байсан үзэл суртал хэмээх зовлонгоос саллаа, одоо соёлт хүмүүн төрөлхтөн ардчилсан үнэт зүйл, чөлөөт эдийн засгийн тогтолцоо бүхий даяар тэгш нийгмийг байгуулан хөгжих тухай таамаг онол олон гарсан.

Гэвч дэлхийн улс орон, соёл иргэншлийн сүүлийн 20 гаруй (ялангуяа сүүлийн арван жилд) жилийн хоорондын харилцаа, тулгуур асуудлууд, зөрчил мөргөлдөөний түүхэн зурвас үеийг нухацтай ажиглаваас, бидний дэлхий дундад зууны загалмайтны аян дайн, газар зүйн их нээлтүүдийн

дараах колоничлолын эрин, аж үйлдвэржилтийн шатан дахь тэгш бус нөөцийн хуваарилалт, хүйтэн дайны үеийн үзэл суртлын зэвсэг зэргээсээ тийм холдож чадаагүй бололтой.

Харин ч мэдээллийн технологийн эрчимтэй хөгжлийн дүнд хормын төдийд дэлхийн сонорт хүрэх “хурдтай” болсон мэдлэг, мэдээллийг баялаг болгохоос илүүтэйгээр өөрийн байр суурийг хамгаалах, бусдыг үгүйсгэх, олон нийтийн ухамсард манипуляци хийх замаар давуу тал бий болгох зэвсэг болгон ашиглах нь давамгайл байна.

Дэлхийн улс орнуудын дуу нэгтэй баталсан олон тунхаг, ардчилсан тогтолцооны нэр зүүсэн төр засгуудын үйлдвэрлэсэн “хүмүүнлиг энэрэнгүй” хууль эрх зүйн орчин, хөгжлийн дээд шатандаа хүрсэн хэмээн цээжээ дэлдэх хүмүүн төрөлхтөн өөрөө ч зорилтот мэдээллийн нөлөөний өмнө хүчин мөхөстөж байна.

Зорилтот мэдээллийг арга хэрэгсэл, нөлөөлөх зарчим, боловсруулан түгээх үйл ажиллагааны хэлбэрийн үүднээс ялган нэрлэсэн олон нэр томьёо бий. Мэдээллийн дайн, мэдээллийн тэмцэл, цөмрөлт (экспанси), суртал ухуулга, олон нийтийн санаа бодлын төөрөгдүүлэлт (манипуляци) гэх мэт нэр томьёог зөвхөн илтгэл, нийтлэлээ чимэглэх “моод” гэдэг утгаар ашиглах бус цэгцтэй нэгдмэл байр сууринаас тодорхойлон ойлгоцгоож, эдгээрийн үр дагавараас сэргийлэх, хамгаалах, үндэсний мэдээллийн дархлааг төлөвшүүлэх асуудал Монголын сэтгүүл зүйд орхигдон мартагдаж, нөгөө талаас хам шинжгүй халдварт өвчин лугаа биднийг “идэж” байна.

Судлаач миний бие энэ удаад мэдээллийн дайн хэмээх ойлголтын

мөн чанарыг илрүүлэх, онолын үүднээс баримттайгаар тайлбарлахыг оролдоно. Ялангуяа Монголын сэтгүүлчдийн түгээмэл хэрэглэдэг хоорондоо ижил төстэй мэт дээрх ухагдахуунуудын ялгаа, мөн чанарыг ойлгон танихгүйгээр ашиглах нь мэдээллийн төөрөгдөл үүсэх бас нэгэн шалтгаан юм.

Мэдээллийн дайн хэмээх ойлголт үндсэн хоёр утгатай¹:

1. Сөргөлдөгч талын иргэд, төр, цэргийнхний хүрээнд тусгайлан боловсруулсан мэдээлэл түгээх замаар нөлөөлөл үзүүлж, улс төр, эдийн засаг, цэрэг армийн, эсвэл өөр стратегийн түвшний зорилгодоо хүрэхийн тулд явуулж буй бүлэг хүмүүсийн (улс орны) үйл ажиллагаа, дээр нэрлэсэн нөлөөллөөс өөрийн талыг хамгаалах үйл явц. Энэ тодорхойлолтын хүрээнд мөн “мэдээлэл, сэтгэл зүйн дайн” (information psychological warfare) гэх нэр томьёо хавсарга хэлбэрээр ашигладаг ба зорилго хэлбэрийн хувьд ижил юм.

2. Өөрийн талын мэдээллийн систем, үйл явц, тодорхой мэдээллийг хамгаалахын зэрэгцээ, сөргөлдөгч талын мэдээллийн систем, үйл явцад хохирол учруулах замаар мэдээллийн давамгайлал бий болгоход чиглэсэн цэрэг, улс төр, тагнуулын зорилтот үйл ажиллагаа.

Судлаачдын тогтоосноор мэдээллийн дайны анхны илрэл болсон үзэгдэл 1853-1856 оны Крымийн дайны түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Нэг талаас Хаант Орос, нөгөө талаас Османы эзэнт гүрэн оролцсон энэ дайны үед Франц, Их Британийн төр эвсэл болж султаны талд дайтан ялалт байгуулсан юм. 1853 оны сүүлийн Синоп хотын тулалдаан мэдээллийг зорилготойгоор гуйвуулан Английн сонинууд турхирсны дүнд Хаант

Оросын эсрэг Османы эзэнт гүрний талд дайнд нэгдэн орох шийдвэрийг Франц, Их Британичууд гаргасан юм. Тухайлбал, Синопын тулалдааны тухай Английн сонинууд бичихдээ: «Орос цэргүүд далайд хөвж буй шархадсан туркүүдийг өршөөл энэрэлгүйгээр буудан “гүйцээж” байлаа»² гэжээ.

Мэдээллийн дайн гэх ойлголт нь онолын хувьд улс орон, төрийн зүтгэлтнүүд байр сууриа баттайгаар илэрхийлэх, хамгаалан үлдэх, түүнийгээ сурталчлах бодит мэдээллийн урсгалаас хальж гардаг бөгөөд үндсэн арга хэрэгсэл нь зохиомол сөрөг мэдээлэл (дезинформац) байдаг.

Энэхүү ойлголтын мөн чанарыг илэрхийлэхүйц зарим шинж тэмдэг ч бий³. Тухайлбал:

- Мэдээллийн дайн нь бие биенээ үгүйсгэсэн үнэт зүйл, засаглалын систем, үзэл баримтлалын үр дүнд нийгмийн бүлгүүдийн дунд өрнөдөг. Ийм бүлгийн тоонд тусгаар тогносон болон хүлээн зөвшөөрөгдсөн улс орнууд, иргэний дайны оролцогч талууд, хүчээр засаглалыг гартаа оруулах зорилго бүхий экстремистүүд (террорист байгууллага бүлэглэл ч багтана), салан тусгаарлагсад ба үндэсний чөлөөлөх хөдөлгөөнүүд багтана.

- Мэдээллийн орон зай дахь энэхүү зөрчил, тэмцэл нь улс төр, эдийн засаг, цэрэг арми гэх мэт нийгмийн суурь салбарууд дахь тэмцлийг өдөөх, дэмжих мөн дагалдах шинжтэй байдаг.

- Стратегийн түвшинд мэдээллийн дайны зорилго нь сэргэлдөгч талын байр суурь, үнэт зүйлийг “нураах”, чадамжгүй болгох мөн өөрийн үнэт зүйлээр солиход оршино. Өөрийн зорилгод ашиглах үүднээс сэргэлдөгч талын мэдээллийн эх үүсвэрүүдийг

эзлэх, шантаажлах, хээл хахууль өгөх зэрэг замаар элсүүлэх нь ч бий.

- Мэдээллийн дайны оролцогч нь төр засгаас зорилготойгоор байгуулсан субъект, ХМХ-үүд байхаас гадна иргэний нийгэм, бүлэг хүмүүс, хувь хүн ч байж болдог.

- Мэдээллийн дайн тасралтгүй үргэлжилж байдаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн зэвсэгт мөргөлдөөн, дайны үед бус энх цагт ч үргэлжлэх нь бий.

- Мэдээллийн дайн нь зорилтот мэдээллийн тэмцлийн хамгийн хатуу, аюултай хэлбэр бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дагаж мөрдөх дүрэм, эрх зүйн орчин, ёс зүй, арга хэрэгслийн хязгаар, хэм хэмжээ гэж үгүй байдаг. Зөвхөн үр дүнгийн төлөөх сэтгэлгээ удирдан залдаг гэсэн үг.

- Хамгийн бохир арга, шууд худал мэдээллээс эхлээд хамгийн нарийн боловсорсон хэлбэр хүртэлх мэдээллийн дамжуулан түгээх бүхий л хэлбэр мэдээллийн дайны үед ашиглагддаг. Мөн хүсэмжит бус (сөрөг талын) мэдээллийг шууд хаах, “хувиргах”, цэвэрлэх тактик их хэрэглэгддэг байна. Олон нийтийн санаа бодлыг удирдан залах энэхүү зорилтот манипуляци нь нэг талыг барьсан мэдээллийн цөм, уурхай болж хувирдаг. Зорилгод нийцэхгүй өөрийн мэдээллийг үл түгээх, эсвэл “цайруулах”, сэргэлдөгч талын мэдээллийг “харлуулах”, “гуйвуулах”, эсвэл бүр зохиох технологи түгээмэл ашигладаг.

- Терроризм, эдийн засаг, дипломат харилцааны тэмцлийн хэрэгслүүд, авлига, барьцаалах, шантаажлах, дарамт шахалт үзүүлэх зэрэг сэтгэл зүйн идэвхтэй нөлөөллийн аргууд нь шууд утгаараа мэдээллийн дайны хэрэгсэл биш боловч хавсарсан холимог хэлбэрээр ашиглагдах нь бий.

- Нөлөөллийн зорилтот бүлэг нь тухайн улс орон, нийгмийн бүлэгт багтах олон нийт иргэд, нийгмийн тодорхой анги, давхарга, бүлэг (тодорхой байгууллага, жишээ нь парламент, ЗГ), эсвэл шийдвэр гаргах түвшний хувь хүн ч байж болдог. Ерөнхийлөгч, ерөнхий сайд, гадаад хэргийн сайд, дипломат төлөөлөгч, цэргийн анги, нэгтгэлийн тэргүүнүүд гэх мэт албан тушаалтан хувь хүн боловч мэдээллийн дайны объект болох боломжтой.

- Сөргөлдөгч талын байр суурь, үнэт зүйл, бүрэн бүтэн байдал, харилцан итгэлцлийг тогтворгүйжүүлэх, хагалан бутаргах, үнэгүйдүүлэх, үгүй хийх нь мэдээллийн дайны зорилтот нөлөөллийн үндсэн чиглэл юм.

- Мэдээллийн нөлөөллийг олон улсын түвшинд шуугисан аливаа скандал, хурц үйл явдлын удирдан залах хэлбэрээр, эсвэл мэдээллийн вакуум (тусгаарлалт) үүсгэх замаар хэрэгжүүлдэг.

- Харь орны, сөргөлдөгч талын зорилго, үйл ажиллагааг дэмжих уур амьсгал тухайн улс, газар нутагт бий болгодог ороо мэдээллийн дайн нь реклам, суртал ухуулга зэргээс ялгарч “дайн” гэсэн нэр томъёогоо бататгадаг. Өөрөөр хэлбэл, зорилтот мэдээллийн нөлөөллийн олон хэлбэр нь нөлөөлөл үзүүлж буй бүлгийн эрх ашигт нийцэж, тэдгээрийн сайн сайханд чиглэж болдог. Харин мэдээллийн дайн тийм биш.

- Мэдээллийн дайныг өрнүүлэх зэр зэвсэг нь ОНМХ, шуудан харилцаа, Интернет, цуурхал гээд мэдээллийг

түгээж, дамжуулж болох бүхий л хэрэгсэл байж болно.

- Баримтыг гуйвуулах, өөрт ашигтайгаар тайлбарлах замаар зорилтот бүлэгт хүчтэй сэтгэгдэл, сэтгэл хөдлөл үүсгэх хэлбэрээр илэрнэ.

Эдгээр шинж тэмдэг нь мэдээллийн дайныг бусад мэдээллийн нөлөөллийн хэлбэрээс ялган таних үндэс болох ба мэдээллийг боловсруулан түгээгч хүн, хэрэгслийг (жишээ нь сэтгүүлч, ОНМХ-үүд өөрсдөө үл ухамсарлан) харанхуйгаар ашиглах боломжтой байдаг нь асуудлыг улам ярвигтай болгодог.

Зохиомол сөрөг мэдээлэл, эсвэл баримтыг гуйвуулан өөрт ашигтай байдлаар боловсруулах нь мэдээллийн дайныг “хөтлөх” үндсэн арга юм. Энэ аргын үр дүнд сөрөг талын газар нутагт үйл явдлын бодит байдлыг “ганхуулах”, олон нийтийн дундах

“ялагдах нь”, эсвэл “тэдний зөв байх” гэсэн сэтгэгдлийг өөгшүүлж дэмжих бололцоо бий болдог. Өөрийн байр суурийг бусдын газар нутагт баталгаажуулах, дэмжлэг олох нь мэдээллийн дайны гол зорилго агаад мөн чанар нь юм.

Мэдээллийн дайн нь нийгэмд ихэвчлэн өөр дэвшилтэт байр суурь, үзэл бодол, хөгжлийн хандлага “санал болгосноор” эхэлдэг ба орчин үеийн геополитик, гадаад ухуулга сурталчилгаа, дипломат харилцааны түүхэнд багагүй орон зайг эзэлж, “үл үзэгдэгч гар”-ын зарчмаар ажилласаар л байна. Магадгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан олон зөрчил мөргөлдөөн,

«

Терроризм, эдийн засаг, дипломат харилцааны тэмцлийн хэрэгслүүд, авлига, барьцаалах, шантаажлах, дарамт шахалт үзүүлэх зэрэг сэтгэл зүйн идэвхтэй нөлөөллийн аргууд нь шууд утгаараа мэдээллийн дайны хэрэгсэл биш боловч хавсарсан холимог хэлбэрээр ашиглагдах нь бий

»

иргэний болон улс хоорондын дайнаас илүү олон талбарт мэдээллийн дайн өрнөж байна.

Үндэстний, эсвэл олон улсын түвшний зөрчил мөргөлдөөн тус бүр мэдээллийн дайныг бий болгож, өөгшүүлэн турхирдаг боловч энх тайван оршиж байгаа газар нутаг, харилцаанд ч мэдээллийн давамгайлал үүсгэх оролдлого, арга хэрэгсэл улам бүр нарийсч буй нь ерөөс “цэвэр сэтгүүл зүй”-н зарчим, асуудлыг бодитойгоор дүгнэн, олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээлэх гэдэг ариун үүрэг нь биелэгдэшгүй мэт, орон зай нь байгаа эсэхэд эргэлзэх сэтгэгдэл төрүүлнэ.

Гэвч мэргэжлийн сэтгүүл зүй, сэтгүүлч хүн хараат бус статусаа хадгалж, услан тэтгэж чадаж гэмээнэ мэдээллийн дайны объект, субъект аль аль нь болж хувирахгүй байх боломжтой.

Мэдээллийн дайныг өрнүүлэх гол талбар нь угаас ОНМХ-ийн систем байдаг. Иймдээ ч зөвхөн илрэл, урьдач үзэгдэл хэлбэрээр Европын хөрөнгөтний хувьсгалууд, колоницлогдож байсан орнуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, дэлхийн нэг, хоёрдугаар дайны үед “бойжиж” байсан энэ ойлголт ОНМХ-ийн систем хөгжин тэлэхийн хэрээр улам төгөлдөршсөн байна. Тухайлбал, 1923 онд байгуулагдсан Их Британийн BBC, Германы DW, 1929 оноос ЗХУ-ын “Голос России” зэрэг олон улсын радионууд, 1980 оноос хүчээ авч хөгжсөн олон улсын сүлжээ мэдээллийн телевизүүд, бидний амьдран буй өнөөгийн ертөнцөд хүчтэй нөлөөлийн хэрэгсэл болж хувирсан Интернет, олон нийтийн сүлжээ гээд өөр өөрийн үед мэдээллийн дайны хэлбэрийг

тодорхойлж, “гоёор будсан” хэрэгслүүд бий болжээ.

Онолын түвшинд хамгийн төгс үргэлжилсэн мэдээллийн дайны хэлбэрт 1946-1991 онд дэлхий нийтийг капитализм, социализмын бүлэгт хуваан талцуулсан Хүйтэн дайныг нэрлэдэг⁴. ЗХУ задарсан үйл явцыг эдийн засгийн шалтгаан, зарим элитийн үзэл баримтлалтай холбохоос гадна АНУ, барууны улс орнуудын идэвхтэй мэдээллийн “бөмбөгдөлт”-ийн үр дүн гэж үзэх хүн олон. Өөрөөр хэлбэл, социалист улс орнуудын хүн ам, элит хүрээнд өрнөсөн мэдээллийн дайны үр дүнд дотоод хагарал, өөрчлөн шинэчлэл бий болж, улмаар ЗХУ задарсан юм.

Логикийн хувьд хүйтэн дайны дараах үе шатанд далайцтай мэдээллийн дайны хэлбэр үгүй байх ёстой мэт боловч өдгөө харин ч энэ асуудал улам хурцаар тавигдаж байна. Учир нь мэдээллийн дайныг зорилготойгоор зохион байгуулдаг субъектүүд нь зөвхөн төр, улс орны удирдлага байхаа больжээ. Мэдээллийг түгээх даяар орон зай нь (тухайлбал, Интернет) шүүлтүүргүй буюу нэгдмэл удирдлага гэж үгүй учир мэдээлэл зөвхөн “онилсон бай”-ндаа тусна гэсэн баталгаа үгүй зэрэг шалтгаан нь даяар мэдээллийн орон зайг улам бүр баталгаагүй, эмзэг, эмх замбараагүй болгож байна.

Ялангуяа 2001 оны 9-р сарын 11-д АНУ-д болсон террорист халдлагаас хойш мэдээллийн дайны жишээ мэргэжлийн сурах бичгүүд, судлаачдын бүтээлийг дүүргэж байна. Иракийн дайн, “арабын хавар” хэмээх хувьсгал, иргэний дайны давалгаа, Сирийн дайн, Украины хямрал, эргэлзээ бүхий улс орнуудын (Исламын Улс бүлэглэл, Хойд Солонгос, Иран, Пакистан,

Израиль–Палестин г. м.) бодлого, түүний эсрэг олон улсын хамтын нийгэмлэгийн хариу арга хэмжээ, цаашлаад өдгөөгийн АНУ, ОХУ гэсэн хоёр том их гүрний бодлого, байр суурийн зөрүү гээд мэдээллийн олон дайны “гал” дунд бид амьдарч байна.

Монгол Улс, манай ОНМХ-үүд хэдийгээр энэ олон мэдээллийн дайны хөлд үрэгдээгүй, үрэгдэх, “онилогдох” нөхцөлгүй мэт боловч бид даяар түвшинд өрнөж буй мэдээллийн тэмцлийн бас нэгэн бай нь яах аргагүй мөн. Тиймээс элдэв мэдээллийн дайралт, нөлөөллөөс өөрсдийгөө хамгаалах “вакцин”-тай байх ёстой.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл, улс үндэстний эрх ашиг, түүний илрэл тодорхой байх, улс төр эдийн засгийн тогвортой, баталгаатай байдал, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл, улс орныхоо төлөөх сэтгэл зүтгэл, эх оронч үзэл — энэ бүхэн дээр дурдсан “вакцин” юм. Завшаанаар, бид өдгөө үеийн томоохон мэдээллийн дайнд оролцогч, эсвэл хохирогч тал биш хэмээн тодорхойлж болох авч Монгол Улсын мэдээллийн дархлаа тун сул байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Мэдээллийн дайны эсрэг дархлаа дээр нэрлэгдсэн “вакцин”-уудыг хүчтэй, баттай байлгаснаар бий болохоос гадна улс орны, санхүү, иргэдийн болон төрийн мэдээллийн баазын аюулгүй байдлыг хангаж, улс орны эрх ашиг, үндэсний байр суурийн талаарх мэдээллийг иргэдэд тогтмол, бодитой, чанартай хүргэснээр төлөвшдөг.

Одоо ойролцоо утгатай ч ялгаатай хэмээн судлаач миний зүгээс онцлоод байгаа зарим ойлголтоо хамгийн энгийнээр товч тайлбарлая.

Мэдээллийн тэмцэл гэдэг нь хууль ёсны арга хэрэгслийн хүрээнд сөргөлдөгч талууд өөрийн байр сууриа хатуу

илэрхийлж, иргэдэд бодит мэдээлэл хүрч буй орчин.

Мэдээллийн дайн гэдэг нь сөргөлдөгч талууд нөлөөлөл бий болгох бүхий л арга хэрэгсэл, заль, дайралтыг мэдээллийн орон зайн салбарт өрнүүлж буй үйл явц. Харин талуудын боломж, хүчин чадал харилцан адилгүйн улмаас нэг тал нь мэдээллийн давамгайлал бий болгож, сөргөлдөгч талын тухай мэдээллийг хаасан, “вакуумжуулсан” бол мэдээллийн цөмрөлт буюу экспанси гэх ойлголтонд багтана⁵.

Иймд орчин үеийн мэдээллийн даяар орон зайд өрнөж буй мэдээллийн дайны илрэлүүдэд ч манай сэтгүүлч, шинжээч, ОНМХ-үүд бодитой үнэлгээ өгч, Монголын гэх эрх ашиг, байр суурь хаана орших талаар мэтгэлцэж байх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, хэн, хаана, хэзээ юу гэсэн асуултын түвшинд олон улсын хурцадмал асуудал өнгөцөөр олон нийтэд хүрч буй нь угаас монголчуудад мэдээллийн дархлаа бий болгохгүй байна. Украин, Сирийн иргэний дайн, Ирак Левантийн Исламын улс хэмээн өөрсдийгөө зарласан террорист бүлэглэлийн талаар Монголын үзэгч, уншигчид чанартай мэдээлэл хүртэхгүй байна. Олон нийтийн санаа бодол төлөвшүүлэх, бий болгох түвшний мэдээллийг аль ч мэдээллийн хэрэгсэл маань бэлтгэхгүй байна.

Украинчууд яагаад байлдаад байгаа юм бол доо, сиричүүд гэж зовсон хүмүүс байнаа гэсэн сэтгэдлийн шинжтэй хандлага л давамгайлж байна. Үүнд зарим нэг шалтгаан байгааг сийрүүлбэл,

- Глобал эх сурвалжуудын цацаж буй өөрсдийн үзэл, байр суурь шингэсэн мэдээллийг манай сэтгүүлч-орчуулагч нар шууд “үгчилсэн”

орчуулгаар хүргэдэг. Иймд Сирийн босогчдыг нэг ХМХ нь салан тусгаарлагчид хэмээн нэрлэж байхад, нөгөө нь үндэсний чөлөөлөх хөдөлгөөн гээд л явж байна. Ирак, Сирийн газар нутгийн томоохон хэсгийг эзлээд байгаа Исламын улс бүлэглэлийн эсрэг ОХУ цэргийн ажиллагаа явуулж эхлэхэд манай сэтгүүлчид “Орос Сирийг бөмбөгдөж эхэллээ” гэсэн өрөөсгөл гарчиг тавиад Башар Асадыг дэмжиж байгаа В.Путин сиричүүдийг бөмбөгдөж байгааг “гайхан” (асуудлыг үл ойлгож байгаагийн шинж) бичиж сууна.

- АНУ Украины хямралын асуудал дээр хууль ёсны Ерөнхийлөгч П.Порошенког өмөөрөн хамгаалж, барууны орнуудтай хамтран ОХУ-ыг эдийн засгийг вакуумд оруулах бодлого барьж байгаа. Гэтэл Сирийн тэргүүн Башар Асад мөн л иргэдээсээ сонгогдсон хууль ёсны Ерөнхийлөгч мөн. Гэтэл Сирийн хямрал Башар Асад суудлаа өгчихвөл шийдэгдчихнэ гэсэн үнэшил муутай байр суурийг сурталчилдаг. Яагаад ядаж энэ хэмжээний тайлбар дүгнэлт, “монгол өнцөг” энэ бүх мэдээлэлд алга байна вэ? Гол асуудал нь Монголын ОНМХ-үүд гадаад мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого гэж зүйл огт алга. Гадаад мэдээний албаны сэтгүүлчийн мэддэг хэл, хувь хүний мэдлэг, ур чадвараас хамаарсан чанаргүй, ашиггүй, идэвхгүй мэдээлэл хүртсээр байна. 2008 онд өрнөсөн Өмнөд Осетийн сэргэлдөөний үеэр манай “Өдрийн сонин”-д өдөр дараалан бие биенээ үгүйсгэсэн шинжтэй мэдээлэл гарч байсан. Шалтгааныг судлаад үзэхэд, орос, англи хэлтэй хоёр орчуулагч ээлжлэн ажилладаг болох нь илэрсэн.

- Монгол Улс олон тулгуурт, нээлттэй гадаад бодлоготой хэмээн тунхагладаг, мөн 1994 оны Үндэсний аюулгүй

байдал гадаад бодлогын тунхагтаа тусгасан байсан төвийг сахисан улсын статусыг саяхан Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж олон улсад зарлаж, албан ёсжуулах кампанит ажлаа эхлүүллээ. Энэ утгаараа Монголын олон улсын харилцааны мэргэжилтнүүд хэнийг ч муулж, шүүмжилж болохгүй гэсэн алтан зарчимтай. Ийм болохоор аливаа олон улсын асуудлын талаар Монгол Улсын байр суурийг зарлах “ёсгүй” гэж бодоцгооно. Угаас ямар байр суурьтай байгаа нь тодорхойгүй, мэдэх, дүгнэх ч хүн байхгүй нөхцөлд сэтгүүлчдийн амыг тагладаг “гайхамшигтай” гарц. Үүний сөрөг үр дагавар нь бид Чингис хаан гэдэг ганц үнэт зүйлтэй, Оюутолгой, Тавантолгой гэсэн хоёр найдвартай, иргэдийн итгэлийг хэн нь ч гарсан эвддэг төрийн гурван өндөрлөгтэй улс болж хувирав.

2008 оны 10-р сарын 3-нд АНУ-ын “Вашингтон пост” сонинд “АНУ-ын байр суурийг дэмжих иргэдийн хандлагыг өсгөх зорилготой мэдээ, мэдээлэл, улс төрийн нийтлэл нэвтрүүлэг, нийгмийн реклам бүтээсэн Иракийн ОНМХ-үүдэд 300 сая хүртэл ам.долларын шагналыг Америкийн батлан хамгаалах яамнаас олгоно” хэмээн мэдээлэв⁶. АНУ, түүний цэрэг, батлан хамгаалах албадын захиалгаар мэдээлэл, сэтгэл зүйн дайны тусгай ажиллагаа хүртэл хийгддэг. Тэдгээр нь тэр бүр ил зарлагдаггүй боловч Иракийн дайны үед “цагаандаа” гарсны илрэл нь дээрх жишээ.

Араб-Израйлийн (Израиль-Палестины гэх нь бий) олон жилийн зөрчил мөргөлдөөн мөн л мэдээллийн дайны арга, технологийг харж болох том сурах бичиг. Энд нээлттэй мэдээллийн өрсөлдөөн эрчимтэй явагдахаас гадна, мэдээллийн сүлжээ, аюулгүй байдалд нь халдах тохиолдол их байдаг.

Тухайлбал, Израилийн JIDF буюу Интернет хамгааллын еврейн хүч нэртэй байгууллага 45 мянган гишүүнтэй “Израиль — улс биш!” гэдэг фейсбүкийн группыг хакердан, блоклож, арабын орнуудын 15 мэдээллийн сайтыг эвдлэн нэвтэрч, нүүр хуудсанд нь Израилийн далбаа, “хакердсан” гэсэн бичиг үлдээсэн зэрэг тохиодлууд саяхных⁷.

Арабын орнууд, Палестиныг дэмжигч бүлэглэлүүд ч мэдээллийн эх сурвалжийг хакердах асуудал дээр өрсөлдөгчөөсөө хол хоцордоггүй ба арабын ОНМХ-үүд Израилийн нэр хүнд, барууны орнуудын байр суурийг унагаах зорилготой зохиомол видео бичлэг ихээхэн цацдаг нь “Палливуд” хэмээх хоч зүүгээд амжсан байдаг.

Мэдээллийн дайн нь хор уршиг бүхий, урт удаан хугацаанд үргэлжилсэн кампанит ажил хэлбэрээр илрэхээс гадна үйл явдлын мэдээлэлд сонгон хэрэглэж буй нэр томъёо, ойлголтын зөрүүг ажиглавал амархан илэрч болдог.

Донецк, Луганск мужид Оросын байр суурийг хамгаалж, Киевтэй сэргөлдөн салан тусгаарлах бодлого барьж буй зэвсэгт бүлгийг барууны хэвлэлүүд экстремистүүд, салан тусгаарлагчид хэмээн цоллож байгаа бол ОХУ-ын мэдээллийн хэрэгслүүд үндэсний чөлөөлөх хөдөлгөөн, хамгаалагчид, партизанууд гэж өргөмжилж байна. Ямар нэр томъёо сонгож байгаагаас л мэдээллийн өнцөг харагдаж байгааг анхаарах хэрэгтэй. Тэр ч байтугай, олон улсын хамтын нийгэмлэгт террорист, алан хядагчид гэж зарлагдсан, хүний төрөлхтний дугаар төддүгээр дайсан хэмээн цоллосон Аль Каида, Хамас, Исламын Улсын тэргүүлэгч нар арабын ертөнц, дэмжин талархдаг, барууны экспансид ядран туйлдсан,

эсвэл мэдээллийн вакуумдаа оршиж буй хүн амын хувьд төр, шашны томоохон зүтгэлтэн, хувьсгалт тэмцэгч, эх орон, үнэт зүйлсээ хамгаалагч байдаг гэдгийг бид олж харах, бодитой дүгнэх, эргэцүүлэх ёстой.

Иймд дүгнэн хэлэхэд, мэдээллийн дайн нь манай сэтгүүлч, улс төрчдийн чамирхан хэрэглэдэг, улс төрийн олон ургальч үзэл, PR-ын хар, цагаан технологитой холбоотойгоор ашиглах түвшний ойлголт биш юм. Харин улс, үндэстэн хоорондын зөрчил, тэмцэл дээр суурилдаг, мэдээллийн үр дүнтэй урсгалыг ашиглан гадаад болон дотоод ертөнцөд, цаашлаад “айлын талд” (сөргөлдөгч талын нутаг дэвсгэрт) давуу байдлыг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа аж.

Ишлэл

1. Фролов Д. Б., Воронцова Л. В. 2004. Информационное противоборство: история и современное состояние. М., с. 23.
2. diggerhistory.info/pages-conflicts-periods/other/crimea.htm
3. Манойло А. В. 2003. Государственная информационная политика в особых условиях. М., с. 388.
4. Кара-Мурза С. Г. 2008. Манипуляция сознанием // karamurza.ru/books/manipul/manipul.htm
5. Уянга Г. 2012. Мэдээллийн дайнд Монгол үндэстэн ялж үлдэх ёстой // <http://news.zindaa.mn/eke>.
6. http://www.vesti.ru/doc.html?id=213657&cid=9&t_only=1
7. Манойло А. В. Информационно-психологическая война: факторы, определяющие формат современного вооружённого конфликта // Материалы V Международной научно-практической конференции «Информационные технологии и безопасность», вып. №8, 2005, с. 73-80.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ.

2. *Зулькафиль М.* 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.

3. *Фролов Д. Б., Воронцова Л. В.* 2004. Информационное противоборство: история и современное состояние. М.

4. *Манойло А. В.* 2003. Государственная информационная политика в особых условиях. М.

5. *Почепцов Г. Г.* 2000. Информационные войны. М.: «Рефл-Бук».

Резюме

Статья посвящена теме о информационной войне, её сути и проявлении.

Автор статьи пытается дать научное определение данному понятию, которое в монгольских СМИ и в кругу политиков толкуется по-разному.

Также в статье “Информационная война и её суть” даётся комментарий к признакам и особенностям информационной войны, уделяется особое внимание современным примерам её проявления в мировом сообществе. Кроме того, автор дает рекомендацию журналистам, как узнать и защищаться от информационной войны в монгольских условиях.